



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 07 өдөр

Дугаар АМЧ

Алтай хот

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 41 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 78.2.6 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 59 дүгээр тогтоолоор баталсан 23 нэр төрлийн автотээврийн хэрэгслүүдийг 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Өмчийн төлөөлөгч: Ж.Билэгсайхан (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)
- Хөтлөгч: Б.Балдорж (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)
- Тэмдэглэл хөтлөгч: Б.Нансалмаа (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)
- Гишүүн: Б.Золжаргал (Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- Г.Хурцгэрэл (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- Д.Үлэмжбаяр (Цагдаагийн газрын Шуурхай удирдлагын тасгийн дарга, дэд хурандаа)
- Д.Ундрахбаяр (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дотоод хяналт төсвийн орлого хариуцсан мэргэжилтэн)

2.Нээлттэй дуудлагын худалдааг хууль, журмын дагуу ил тод зохион байгуулж, дүнг холбогдох байгууллагад танилцуулж ажиллахыг комисс (Ж.Билэгсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

